ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2023/75/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Аудитор: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 261740 Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг<br>Утас: 70169029 Цахим хаяг:info@misheelodaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/415
танай ____________-ны № ____________-т

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус сургууль нь Кембрижийн олон улсын сургалтын хөтөлбөрийн хүрээнд дэлхийн жишигт нийцсэн өрсөлдөх чадвартай хүмүүнлэг монгол иргэдийг бэлтгэх зорилгоор олон улсын болон үндэсний хөтөлбөрийг хослуулан хэрэгжүүлж байна.

Монгол Тэмүүлэл сургууль нь сурагчдад 9 дүгээр ангид нь үндэсний хөтөлбөрийн 13 хичээлийг судлан суурь боловсрол эзэмшүүлдэг бөгөөд 10 дугаар ангиас эхлэн үндэсний хөтөлбөрөөр судлах хичээлийн тоог багасаж, ирээдүйд эзэмших мэргэжил, сурагч бүрийн сонирхол, хэрэгцээнд нь нийцүүлэн англи хэл дээр судлах хичээлийн агуулгыг нэмэгдүүлдэг.

Эдгээр чиглэлийн хүрээнд эрх бүхий байгууллагаас 2019 онд олгосон “Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 5 жилийн хугацаагаар сунгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд нэмэлт төсвийн дансанд тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгыг Ерөнхий боловсролын 133 дугаар сургуульд түр ашиглуулж байгаатай холбоотойгоор ашиглалтын зардлын санхүүжилт 60,060.1 мянган, Нийслэлийн

Z:\Yawsan_Bichig\2023\0224 SNAG-51.Docx

0001050698

боловсролын газраас гүйцэтгэлийн үр дүнгийн шагналыг шилдэг багшид олгох санхүүжилт 1,000.0 мянган, нийт 61,060.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Тайлант жилийн түрээсийн зардал 418,390.2 мянган төгрөгийг БШУЯ хариуцан төлөхөөр гэрээнд тусгаж, үүнээс 209,195.1 мянган төгрөгийг төлж үлдэгдэл 209,195.1 мянган төгрөгийг тус сургууль төлж, түрээсийн зардлыг дутуу тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 92.1 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,244,683.80** | **50,409,605.16** |
| **33** | **АВЛАГА** | **397,705.69** | **71,198.16** |
| **33500** | **Бусад авлага** | **397,705.69** | **71,198.16** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 397,705.69 | 71,198.16 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **47,846,978.11** | **50,338,407.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **47,846,978.11** | **50,338,407.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,389,637.00 | 1,923,810.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,273,961.11 | 29,562,486.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,901,910.00 | 240,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,281,470.00 | 18,612,111.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,890,871,147.74** | **3,751,655,954.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,890,871,147.74** | **3,751,655,954.74** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **3,890,097,814.41** | **3,750,380,954.74** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,456,901,301.72 | 3,456,901,301.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (263,477,232.50) | (370,810,541.36) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 49,228,166.50 | 49,228,166.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,367,449.07) | (17,776,837.91) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 243,354,550.44 | 260,053,747.72 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (144,134,181.36) | (86,608,404.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 189,283,304.10 | 169,880,298.05 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (74,317,953.78) | (73,819,571.19) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 653,998,698.28 | 653,998,698.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (241,410,339.92) | (313,640,752.27) |
| 39217 | Ном | 22,038,950.00 | 22,974,850.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **773,333.33** | **1,275,000.00** |
| 39301 | Программ хангамж | 6,056,980.00 | 1,702,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,283,646.67) | (427,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,939,115,831.54** | **3,802,065,559.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **33,360.45** | **38,600.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **33,360.45** | **38,600.00** |
| **41300** | **Өглөг** | **33,360.45** | **38,600.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 33,360.45 | 0.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **38,600.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 38,600.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,939,082,471.09** | **3,802,026,959.90** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,939,082,471.09** | **3,802,026,959.90** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 265,942,620.50 | 265,942,620.50 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 265,942,620.50 | 265,942,620.50 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,673,139,850.59** | **3,536,084,339.40** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,846,310,733.61 | 3,620,640,598.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (173,170,883.02) | (84,556,258.66) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,939,115,831.54** | **3,802,065,559.90** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,744,949,007.50** | **2,084,240,112.17** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **119,728,997.50** | **93,934,017.17** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **114,728,997.50** | **93,934,017.17** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **109,217,567.50** | **40,734,460.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,930,000.00 | 40,734,460.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 85,287,567.50 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 53,199,557.17 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 5,511,430.00 | 0.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **5,000,000.00** | **0.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,000,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,625,220,010.00** | **1,990,306,095.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,588,560,600.00** | **1,929,246,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,588,560,600.00 | 1,929,246,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **36,659,410.00** | **61,060,095.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,659,410.00 | 60,060,095.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,904,979,067.26** | **2,168,796,370.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,904,979,067.26** | **2,168,796,370.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,692,871,937.25** | **2,103,057,571.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,026,503,216.88** | **1,255,163,032.13** |
| 210101 | Үндсэн цалин | 613,993,499.06 | 739,633,723.49 |
| 210102 | Нэмэгдэл | 302,656,108.36 | 408,289,645.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,680,173.31 | 63,737,376.28 |
| 210104 | Урамшуулал | 56,173,436.15 | 43,502,286.39 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **133,262,143.69** | **155,499,395.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,936,170.48 | 107,335,662.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,431,646.46 | 12,626,443.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,234,275.52 | 10,027,235.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,855,799.27 | 2,269,608.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,804,251.96 | 23,240,445.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,659,409.00** | **269,255,194.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,523,763.30 | 24,636,135.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,294,328.70 | 14,358,684.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,841,317.00 | 21,065,275.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 209,195,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **86,362,785.32** | **140,781,860.61** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,651,927.00 | 11,506,877.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,611,500.00 | 5,594,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,859,063.48 | 22,891,123.80 |
| 210404 | Ном, хэвлэл | 456,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,948,000.00 | 6,350,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 50,836,294.84 | 94,439,249.81 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,027,500.00** | **4,252,061.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 945,470.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 3,306,591.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,027,500.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,547,866.78** | **0.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,547,866.78 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **64,604,462.00** | **44,606,900.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,848,932.00 | 42,628,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 186,030.00 | 314,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,500.00 | 131,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **337,904,553.58** | **233,499,127.64** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 6,540,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 129,205,812.60 | 11,395,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 208,698,740.98 | 215,563,377.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **212,107,130.01** | **65,738,799.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **58,000,000.00** | **28,331,606.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 42,000,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,000,000.00 | 28,331,606.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **154,107,130.01** | **37,407,193.71** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 154,107,129.01 | 37,407,193.08 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1.00 | 0.63 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(160,030,059.76)** | **(84,556,258.66)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **13,140,823.26** | **0.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 13,140,823.26 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(173,170,883.02)** | **(84,556,258.66)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,649,150,010.00** | **2,031,027,595.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,930,000.00** | **40,721,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **23,930,000.00** | **40,721,500.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **23,930,000.00** | **40,721,500.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,930,000.00 | 40,721,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,625,220,010.00** | **1,990,306,095.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,588,560,600.00** | **1,929,246,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,588,560,600.00 | 1,929,246,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **36,659,410.00** | **61,060,095.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,659,410.00 | 60,060,095.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,601,581,900.00** | **1,955,379,715.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,601,581,900.00** | **1,955,379,715.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,389,474,769.99** | **1,888,565,935.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,026,458,182.27** | **1,254,869,885.05** |
| 210101 | Үндсэн цалин | 613,948,464.45 | 732,268,574.56 |
| 210102 | Нэмэгдэл | 302,656,108.36 | 415,361,647.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,680,173.31 | 63,737,376.28 |
| 210104 | Урамшуулал | 56,173,436.15 | 43,502,286.39 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **133,108,997.24** | **155,499,395.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,567,297.42 | 107,335,662.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,431,646.46 | 12,626,443.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,234,275.52 | 10,027,235.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,855,799.27 | 2,269,608.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,019,978.57 | 23,240,445.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,659,409.00** | **269,255,194.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,523,763.30 | 24,636,135.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,294,328.70 | 14,358,684.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,841,317.00 | 21,065,275.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 209,195,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **57,408,647.48** | **69,066,109.50** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,590,964.00 | 4,147,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,249,910.00 | 3,932,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,657,823.48 | 22,891,123.80 |
| 210404 | Ном, хэвлэл | 425,600.00 | 8,954,341.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,154,500.00 | 6,610,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,329,850.00 | 22,530,294.70 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,797,500.00** | **0.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,797,500.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0.00** | **284,980.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 284,980.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **45,052,922.00** | **65,306,694.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 43,297,392.00 | 59,293,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 186,030.00 | 314,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,500.00 | 93,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 0.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 4,072,894.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **87,989,112.00** | **74,283,677.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 6,481,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 87,989,112.00 | 67,802,477.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **212,107,130.01** | **66,813,779.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **58,000,000.00** | **29,406,586.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 42,000,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,000,000.00 | 29,406,586.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **154,107,130.01** | **37,407,193.71** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 154,107,129.01 | 37,407,193.08 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1.00 | 0.63 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **47,568,110.00** | **75,647,880.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **47,568,110.00** | **75,647,880.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **47,568,110.00** | **75,647,880.00** |
| **VI** | **Дотоод эх үүсвэрээр** | **47,568,110.00** | **75,647,880.00** |
| VI | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 47,568,110.00 | 75,647,880.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(47,568,110.00)** | **(75,647,880.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **265,942,620.50** | **0.00** | **3,846,310,733.61** | **4,112,253,354.11** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **265,942,620.50** | **0.00** | **3,846,310,733.61** | **4,112,253,354.11** |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (173,170,883.02) | (173,170,883.02) |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **265,942,620.50** | **0.00** | **3,673,139,850.59** | **3,939,082,471.09** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (52,499,252.53) | (52,499,252.53) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **265,942,620.50** | **0.00** | **3,620,640,598.06** | **3,886,583,218.56** |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (84,556,258.66) | (84,556,258.66) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **265,942,620.50** | **0.00** | **3,536,084,339.40** | **3,802,026,959.90** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,969,246,000.00** | **1,932,560,306.92** | **36,685,693.08** | **98.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,969,246,000.00** | **1,932,560,306.92** | **36,685,693.08** | **98.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,918,735,700.00** | **1,904,153,720.92** | **14,581,979.08** | **99.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,259,208,900.00** | **1,254,869,885.05** | **4,339,014.95** | **99.6** |
| 210101 | Үндсэн цалин | 471,382,500.00 | 732,268,574.56 | (260,886,074.56) | 155.3 |
| 210102 | Нэмэгдэл | 398,227,600.00 | 415,361,647.82 | (17,134,047.82) | 104.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,334,600.00 | 63,737,376.28 | (8,402,776.28) | 115.2 |
| 210104 | Урамшуулал | 334,264,200.00 | 43,502,286.39 | 290,761,913.61 | 13.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **157,401,000.00** | **155,499,395.37** | **1,901,604.63** | **98.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,547,900.00 | 107,335,662.29 | 2,212,237.71 | 97.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,963,300.00 | 12,626,443.88 | (663,143.88) | 105.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,570,600.00 | 10,027,235.11 | (456,635.11) | 104.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,392,600.00 | 2,269,608.17 | 122,991.83 | 94.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,926,600.00 | 23,240,445.92 | 686,154.08 | 97.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **209,196,000.00** | **209,195,100.00** | **900.00** | **100.0** |
| 210304 | Байрны түрээс | 209,196,000.00 | 209,195,100.00 | 900.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **75,373,000.00** | **70,002,009.50** | **5,370,990.50** | **92.9** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,164,700.00 | 4,147,650.00 | 17,050.00 | 99.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,011,200.00 | 3,932,700.00 | 78,500.00 | 98.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,595,500.00 | 22,891,123.80 | 704,376.20 | 97.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,318,800.00 | 9,890,241.00 | 2,428,559.00 | 80.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,022,400.00 | 6,610,000.00 | 1,412,400.00 | 82.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,260,400.00 | 22,530,294.70 | 730,105.30 | 96.9 |
| **2105** | **Нормативт зардал** | **43,200.00** | **0.00** | **43,200.00** | **0.0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 43,200.00 | 0.00 | 43,200.00 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **71,420,400.00** | **71,226,960.00** | **193,440.00** | **99.7** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 71,420,400.00 | 71,226,960.00 | 193,440.00 | 99.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **69,341,100.00** | **66,806,694.00** | **2,534,406.00** | **96.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,547,900.00 | 60,793,500.00 | 754,400.00 | 98.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,166,600.00 | 1,500,000.00 | 666,600.00 | 69.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 314,200.00 | 314,000.00 | 200.00 | 99.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,300.00 | 93,300.00 | 50,000.00 | 65.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 36,400.00 | 33,000.00 | 3,400.00 | 90.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,132,700.00 | 4,072,894.00 | 1,059,806.00 | 79.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **76,752,100.00** | **76,553,677.00** | **198,423.00** | **99.7** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,672,500.00 | 6,481,200.00 | 191,300.00 | 97.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 70,079,600.00 | 70,072,477.00 | 7,123.00 | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,510,300.00** | **28,406,586.00** | **22,103,714.00** | **56.2** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **50,510,300.00** | **28,406,586.00** | **22,103,714.00** | **56.2** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,412,000.00 | 0.00 | 9,412,000.00 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 41,098,300.00 | 28,406,586.00 | 12,691,714.00 | 69.1 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,969,246,000.00** | **1,932,560,306.92** | **36,685,693.08** | **98.1** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,929,246,000.00** | **1,891,838,806.92** | **37,407,193.08** | **98.0** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,929,246,000.00 | 1,891,838,806.92 | 37,407,193.08 | 98.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **40,000,000.00** | **40,721,500.00** | **(721,500.00)** | **101.8** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,000,000.00 | 40,721,500.00 | (721,500.00) | 101.8 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **83** | **83** | **0** | **100.0** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | **0** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **41** | **41** | **0** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | **0** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 39 | 39 | **0** | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | **0** | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **61,060,095.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **61,060,095.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **60,060,094.37** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **60,060,094.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 24,636,135.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 14,358,684.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 21,065,275.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,000,000.63** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **1,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **0.63** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | | 0.63 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **61,060,095.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **61,060,095.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 60,060,095.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 78,985.4 мянган төгрөгийн 8 алдаа илэрснээс 78,985.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 7 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 1 алдаанд зөвлөмж өгсөн.

Аудитаар 6,669.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах 645.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6,023.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 6,669.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон 38,362.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтын дагуу толилуулаагүй, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлага цэвэр зээлийн дүнг 37,407.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, мөн цахим системд алдаатай шивсэн. | 1 | 37,407.2 | | | 1 | 37,407.2 | 1 | 37,407.2 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг гэсэн ангилалд 16,000.0 мянган төгрөгийн зардал толилуулсан нь өмнөх аудитын тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн. | 1 | 16,000.0 | | | 1 | 16,000.0 | 1 | 16,000.0 | | | | |
| Номын үлдэгдэлд элэгдэл тооцож бүртгэсэнтэй холбоотойгоор санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн дүн нь товчоо тайлангийн дүнгээс 1,086.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Мөн 478 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын жилийг (-1) утгатайгаар үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байна. | 1 | 1,086.1 | | | 1 | 1,086.1 | 1 | 1,086.1 | | | | |
| Тайлант жилийн элэгдлийн зардлыг 1,278.7 мянган төгрөгөөр дутуу тооцож бүртгэсэн. | 1 | 1,278.7 | | | 1 | 1,278.7 | 1 | 1,278.7 | | | | |
| Тайлант оны гуравдугаар улиралд хамаарах 4,256.5 мянган төгрөгийн дулаан, усны зардлыг аккруэл сууриар бүртгээгүй, санхүүгийн тайланд зардлыг дутуу тайлагнасан. | 1 | 4,256.5 | | | 1 | 4,256.5 | 1 | 4,256.5 | | | | |
| Үндсэн цалингийн зардлын дансанд ХХОАТ-ын өр дансыг бууруулан 7,472.3 мянган төгрөгөөр зардал бууруулсан стандарт бус гүйлгээ бүртгэсэн. | 1 | 7,472.3 | | | 1 | 7,472.3 | 1 | 7,472.3 | | | | |
| Цалингийн зардлыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгээгүйгээс цалингийн хүснэгтэд тусгагдсан тооцогдсон цалингийн дүнгээс 11,484.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. | 1 | 11,484.6 | | | 1 | 11,484.6 | 1 | 11,484.6 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тус сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,571,378.3 мянган төгрөгийн барилга байгууламжийг Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуульд ашиглуулж байгаа боловч балансаас балансад шилжүүлээгүй, тус сургуулийн үйл ажиллагаанд хамааралгүй 77,493.6 мянган төгрөгийн элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Мөн тайлант жилийн түрээсийн зардал 418,390.2 мянган төгрөгийг БШУЯ төлөхөөр гэрээнд тусгасан боловч 209,195.1 мянган төгрөгийг БШУЯ хариуцан төлж үлдэгдэл 209,195.1 мянган төгрөгийг 2022 оны 12 сард тус сургуулийн төсөвт тодотгол хийж тухайн сургуулиас төлүүлж төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн, зардлыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан. | 1 | | 1 | | | | | | 1 | | 1 | |
| **Дүн** | **8** | **78,985.4** | **1** | **0** | **7** | **78,985.4** | **7** | **78,985.4** | **1** | **0** | **1** | **0** |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Илүү цагийн хөлсийг тооцож олгохдоо сүүлийн 3 сарын цалин хөлсний дунджаар тооцоогүйгээс 3 ажилтны 1 сарын илүү цагийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад 645.6 мянган төгрөгийг дутуу олгосон. | 1 | 645.6 | 1 | 645.6 | | |
| Тайлант оны 12 сард байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн төсөвт тодотгол хийж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын ангиллаас улирлын үр дүнгийн урамшууллаас гадна 25,098.3 мянган төгрөгийн үр дүнгийн нэмэлт урамшууллыг ажилтнуудад олгосон. Мөн тус урамшууллаас 6,023.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулахгүйгээр ажилтнуудад олгосон. | 1 | 6,023.6 | | | 1 | 6,023.6 |
| **Дүн** | **2** | **6,669.2** | **1** | **645.6** | **1** | **6,023.6** |

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Дүн | Дүн | Дүн | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| Тайлант оны 3,8,9,10-р саруудад амралтын өдөр ажилласан 59 ажилтанд 14,861.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг 12 сард тооцож олгосон. | 1 | 14,861.5 | 1 | 14,861.5 | | |
| Удирдах зөвлөлийн хурлаар баталсан сургуулийн дүрэмд бүтэц орон тоог 68 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан. Тайлант онд 63 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд орон тоог 41-ээр тусгаж 22 орон тоог дутуу тайлагнасан байна. | 1 | | | | 1 | |
| **Нийт дүн** | **2** | **14,861.5** | **1** | **14,861.5** | **1** | |